



## АКАДЕМИК ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН-2020 Essay Competition 2020

ШУС-ийн ХУС-ын Гадаад Хэлний Төвөөс МУИС-ийн англи хэлний хичээлийг англи хэлний мэргэжлийн бус, ахисан дунд түвшинд судалдаг оюутнуудын дунд “Академик Эссэ Бичлэг”-ийн уралдааныг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай. Энэ удаад Ковид-19 Цар тахлын улмаас тус уралдааныг *онлайн хэлбэрээр* зохион байгуулах боллоо.

### **Тэмцээний зорилго:**

Англи хэлийг сонгон суралцаж байгаа оюутнуудын АКАДЕМИК БИЧИХ ЧАДВАР-ыг улам сайжруулах, бататгах, ажлын байранд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бусдыгаа манлайлахад дадалжуулах зорилготой.

**Хэзээ:** 11-р сарын 27ны Баасан гаригт 16 цагт

**Үргэлжлэх хугацаа:** 60 мин

**Хаана:** Эссэний уралдааныг онлайн явуулах бөгөөд бүртгэл хийлгэснээр оролцох холбоосыг хүлээн авах юм. Тэмцээнийг **MICROSOFT FORMS** платформоор зохион байгуулах тул та бүхнийг идэвхтэй оролцохыг урьж байна.

### **Хамрах хүрээ, түвшин:**

МУИС-ийн англи хэлний мэргэжлийн бус, ахисан дунд түвшинд суралцдаг оюутнууд

### **Эссэг шалгаруулах журам:**

Шүүгчдийн бүрэлдэхүүн онооны системээр 1-5 дугаар байр эзлүүлж, өргөмжлөл, дурсгалын зүйлс хөл хорио дууссаны дараа тодорхой өдөр товлон шалгарсан оюутнуудад мэдэгдэн гардуулна. Эхний 5 байр эзэлсэн оюутнуудад Торгоны замын их сургуулиудын холбооноос (SUN) зохион байгуулагддаг WRICOS Олон Улсын эссэний уралдаанд оролцох эрх нээгдэнэ.

**Эссэний сэдэв:** Тухайн линкрүү орон 2-3 өгөгдсөн сэдвээс сонгон бичих болно.

**Зөвлөмж:** Plagarism буюу аливаа интернэт болон бусад эх сурвалжаас хуулсан тохиолдолд эссэг шууд хасах бөгөөд хуулсан эсэхийг шалгадаг хэд хэдэн програмыг ашиглан шалгах болно. Иймд ямар нэгэн эх сурвалжаас хуулан бичихгүй байхыг зөвлөж байна.

**Эссэнд тавигдах агуулгын шаардлага:**

*Асуудлыг зөв тодорхойлсон, логик уялдаатай байх*

*Дүрмийн болон хэлзүйн, утга найруулгын алдаагүй байх*

*Академик эссэний түгээмэл тогтсон бүтцээр бичих*

*Үгийн сан оновчтой байх, өгүүлбэрзүйн бүтэц ойлгомжтой байх*

*Үгийн тоо 500 ± 50*

**БҮРТГЭЛ**

2020 оны **11-р сарын 21-ны өдрөөс 11-р сарын 25-ны 18 цаг** хүртэл

<https://forms.gle/2mdTXsQBvCAf4ZvT6> холбоосоор орон бүртгүүлэнэ үү.

**Жич:** Таны бүртгүүлсэн мэйл хаяг нь МУИС-ийн албан ёсны мэйл хаяг байх ёстой ([StudentID@stud.num.edu.mn](mailto:StudentID@stud.num.edu.mn)) бөгөөд та зөвхөн тус хаягаар Эссэний уралдааны линкэд нэвтрэх эрхтэй юм.